

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-15
1. Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох	6-10
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	10
3. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	11-15

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 07-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 07 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Мөнхсоёл, Б.Чойжилсүрэн;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, П.Мөнхтулга.

Нэг.Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч С.Магнайсүрэн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын Ерөнхий аудиторт нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням нар танилцуулав.

Нэр дэвшигч болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5

Бүгд: 19
73.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 0
Бүгд: 19
100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 0
Бүгд: 19
100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, П.Ганзориг, Да.Цогтбаатарын нарын бүрэлдэхүүнтэй тооллогын комисс байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 0
Бүгд: 19
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 1.Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 0
Бүгд: 18
100 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 0
Бүгд: 18
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Б.Заяабал, Ж.Баясгалан, Р.Батболд, Д.Батбаяр, П.Ганзориг нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 84.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, мөн газрын Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт Ш.Бумаажав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням уг асуудалтай холбогдуулан Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж ажиллах шаардлагатай байгаа тул хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 14
Бүгд: 19
26.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн техникийн саатлын улмаас Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Горимын санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан уг асуудлыг хойшлуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 47 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим, 12 цаг 07 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг дахин эрье.

Хуралдаанаа үргэлжлүүлээд өмнөх ирцээр Төсвийн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааныг эхлүүлье. Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн ирж, 76 хувьтай байгаа учраас хуралдааныг нээе. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Эхний асуудал. Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсоно.

2-т “Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ.

3-д Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гэсэн ийм 3 асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Нэлээн цуцсан бололтой байна. Эхний асуудалд орёе.

Эхний асуудал Монгол Улсын Ерөнхий аудитын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж эхэлнэ.

Их Хурлын дарга орж ирж танилцуулахаар байгаа. Их Хурлын даргыг урья.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно.” гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооноос нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа.

Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд санал болгосон нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын дарга Дашзэвэгийн Амарбаясгалан танилцуулна. Амарбаясгалан дарга.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангаж байгаа Сандагийн Магнайсүрэнг Төрийн аудитын тухай

хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Сандагийн Магнайсүрэн 1975 онд төрсөн. 50 настай. 1983-1993 онд Говь-Алтай аймгийн 1 дүгээр 10 жилийн дунд сургууль, 1993-1997 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Хууль зүйн шинжлэх ухааны магистрын зэрэгтэй.

Ажилласан байдал. 1997-1999 онд Улаанбаатар эрдэм дээд сургуульд багш, тэнхимийн эрхлэгч, 1999-2000 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Улсын Их Хурлын гишүүний туслах, 2000-2005 онд Улсын Их Хурлын Тамгын газарт зөвлөх, 2005-2006 онд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, 2006-2007 онд Хүнс, хөдөө аж ахуйн яаманд сайдын зөвлөх, 2007-2008 онд Сангийн яаманд газрын дарга, 2008-2013 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Тамгын газрын нарийн бичгийн дарга, 2015 онд Хөдөлмөрийн яаманд Төрийн нарийн бичгийн дарга, 2015-2023 онд Барилга, хот байгуулалтын яаманд Төрийн нарийн бичгийн дарга, 2023-2024 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Төрийн нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байсан. Эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд буюу тэргүүн түшмэлийн албан тушаалд 12 жил 5 сар ажилласан байна.

Түүнчлэн Япон Улсын хамтын ажиллагааны байгууллагад хоршооны хөгжлийн чиглэлээр, Бүгд Найрамдах Австри Улсын ОУВС-д Төв банк, санхүүгийн чиглэлээр, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хамтын ажиллагааны агентлагт цахим архивын чиглэлээр, Америкийн Нэгдсэн Улсын Орт коллежид англи хэл, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Төрийн удирдлагын академид Төрийн захиргааны чиглэлээр тус тус мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байсан.

Төрийн аудитын тухай хуулийн 28.2-т заасан 45 насанд хүрсэн ш, эдийн засаг, санхүү, эсвэл хууль зүйн чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй байх, төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан байх, сүүлийн 6 жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх, харшлах ажил, албан тушаал давхар эрхэлдэггүй, аж ахуйн нэгж мэргэжлийн болон төрийн бус байгууллагад ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлагыг хангаж байна гэж үзэж Сандагийн Магнайсүрэнг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилуулахаар нэр дэвшүүлж байна. Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Их Хурлын дарга танд баярлалаа. Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 8 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдөр явуулахаар товлож, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямьг сонсгол дарлагчаар сонгон, сонсголыг зохион байгуулсан. Энэхүү сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулна. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Эрхэм Их Хурлын дарга, Төсвийн байнгын хорооны дарга болон эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг дахин хүргэе.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлангийн танилцуулгыг хүргэе.

Монгол Улсын Их Хурлын даргаас Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг Улсын Их Хуралд санал болгосон.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйл, мөн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 8 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулахаар товлож, 14 хоногийн хугацаанд сонсголд оролцогчдыг бүртгэх болон нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаарх саналыг хүлээн авахаар сонсголын зарыг олон нийтэд хүргэсэн.

2.Монгол Улсын Ерөнхий аудит албан тушаалд нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням даргалж, сонсголд Төсвийн байнгын хорооны гишүүд нэр дэвшигч С.Магнайсүрэн болон зарын дагуу бүртгүүлсэн 6 оролцогч, 2 ажиглагч иргэн оролцлоо.

3.Нэр дэвшигчийн сонсголыг сонсгол даргалагч нэр дэвшигчийн талаар товч танилцуулж, үүний дараа нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа танилцуулж дууссаны дараа оролцогч Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлсэн болно.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигч Магнайсүрэнг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэж дэмжсэн болно.

Танилцуулгыг уншиж дууслаа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулж явуулсан Дамдинням гишүүнд баярлалаа. Одоо Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшүүлэх эрх бүхий албан тушаалтны санал, нэр дэвшигчийн сонсголын тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Чуулганаар орно. Нэр дэвшигчээс хандаж үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Сая сонсгол сайн явсан учраас сонсгол дээр асуулт, үг хангалттай явжээ гэж ингэж ойлгож байна.

Ингээд гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Санал хураалт чинь нууцаар явж байгаа юу. Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дахиад явуулъя. Дахиад хураачихъя. Би түрүүн техникийн саатал гарсан учраас дахиад явуулъя гээд хэлчихсэн учраас

дахиж явуулах нь зүйтэй. Одоо ингээд техникийн саатал арилсан учраас Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Минийх ажилласангүй. Өөр хэн хэнийх ажилласангүй. Минийх ажилласангүй. Энэ чинь нэлээн олон хүн байна шүү дээ. Аубакир гишүүн гээд. Тэгвэл би санал гаргая. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ингээд 19 гишүүн санал хураалтад оролцож, 14 дэмжиж өмнөх санал хүчингүй боллоо.

Одоо Монгол Улсын Ерөнхий аудитын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор дахин санал хураалт явуулъя. Төхөөрөмж хэдэн хүнийх гацав. 11 хүний төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас энэ саатал хураалтыг хүчингүйд тооцъё.

Одоо дахиад нэг оролдоод үзье. Техникийн саатлын засчихлаа гээд байна. Дахиад 1 үзье. Болохгүй бол тэгээд цаасаар санал хураалт явуулъя. Түрүүний саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя. Бүр байхгүй болчихлоо шүү дээ. Бүр санал хураалт явагдахгүй байна шүү дээ.

Гишүүд ээ, одоо тэгвэл хэдүүлээ цаасаар санал хураалт явуулъя тэгэх үү. Эхлээд ингэе. Хэдүүлээ гар өргөж санал хураалт явуулах билүү. Техникийн саатал гарч байгаа учраас техникийн бэлэн байдал хангагдахгүй байгаа учраас гар өргөж санал хураалт явуулъя гэдгээр санал хураалт явуулчихъя. Тоолоорой. Хэд вэ. 100 хувийн санал. Одоо өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг гар өргөж явуулна. Тэгээд дараа нь нөгөө юугаар явуулна шүү. 100 хувь. Өмнөх санал хураалт хүчингүй боллоо.

Одоо ингээд цаасаар, нууцаар нэр дэвшигчийг томилох санал хураалт явагдана. Нөгөө цаасаар санал хураалт явуулах учраас тооллогын комисс сонгох юм байна. Ганхуяг ахлаад, Ганхуяг, Цогтбаатар, Ганзориг 3. Ганхуяг ахлаад ингээд комиссыг баталъя. 100 хувийн санал хураалтаар Ганхуяг даргатай комисс томилогдлоо. Комисс ажилдаа оръё. Санал хураалтыг эхлүүлъя.

Тийм, Үгүй гэсэн 2 багана байгаа. Дэмжиж байгаа гишүүн тийм гэдэг дээр дарна, дэмжээгүй гишүүн үгүй гэдэг дээр тэмдэглэнэ. Тэмдэглэнэ. Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Энэ дээр цаасан дээр ингэх нь байна шүү. Манайхан сонсож байгаарай. 2 санал оруулалт биш шүү. Энэ доор нь нэр дэвшигчийн нэр байгаа. 1 номер гэсэн дээр. Тэрний ар дээр нь тийм, үгүй гэдгийнхээ аль нэгийг нь л чагт тавина гэсэн үг. 1 номер дээр Сандагийн Магнайсүрэн гэсэн нэр байгаа. Тэрний ард зай байгаа. Тэр дээр тийм, үгүй гэсэн аль нэгийг нь сонгоод, чагтлаад л болно.

Ц.Даваасүрэн: Комиссын дарга Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Тооллогын комисс Цогтбаатар гишүүн, Ганзориг гишүүн, Ганхуяг гишүүн нар ажиллалаа. 18 гишүүн санал хураалтад оролцсон байна. Санал хураалт нууцаар явагдсан бөгөөд 18 саналаас 18 нь нэр дэвшигчийг дэмжсэн байна. 100 хувийн саналаар дэмжигдсэн байна. Баяр хүргэе.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд Сандагийн Магнайсүрэнг томилъё гэсэн саналыг 18 гишүүнээс 18 гишүүн дэмжиж 100 хувийн санал хураалтаар дэмжигдсэн байна.

Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт хийе. Гар өргөж явуулна, гар өргөө л. Ингээд 18 гишүүн оролцож, 18 гишүүн дэмжиж Загджав даргыг чөлөөллөө. Ингээд чөлөөлөх санал хураалт дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшүүлсэн санал, нэр дэвших сонсголын тайланг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшүүлсэн санал нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Магнайсүрэн явж байж болно амжилт хүсье.

12.28 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай асуудал байгаа.

Энэ асуудлыг хэлэлцэж эхэлье. Цаглаварын боловсруулсан төслийг та бүхэнд тараасан байгаа. Энэ цаглаварын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Төслийн цаглаварын төсөл тараасан байгаа даа. Тараачих.

Тогтоолтой холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу. Алга.

“Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Төсвийн байнгын хороо хэлэлцэх асуудлын цаглаварыг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 19-10 гишүүн дэмжиж, 52,6 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Мэндсайхан гишүүн, Заяабал гишүүн, Баясгалан гишүүн, Батболд, Батбаяр гишүүн нарыг дэмжсэнээр авлаа. Ганзориг гишүүнийг бас дэмжсэнээр авлаа. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

12.38 цаг.

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд Засгийн газраас хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Улсын Их Хуралд ирүүлнэ гэж уг тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр заасны дагуу **Засгийн газраас хууль, Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын**

хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан ирүүлснийг Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хамаарах хүрээнд хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.2-т заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, дүн шинжилгээ ирүүлснийг та бүхэнд тараасан байгаа. Ажлын хэсэгт Э.Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Ч.Өнөрбаяр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Д.Үүрийнтуяа Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга, Ш.Бумаажав Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын Хууль тогтоомж, тогтоол шийдвэр хариуцсан референт, Д.Отгон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт гэсэн ийм хүмүүс оролцож байна. Засгийн газраас ирүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн талаарх илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга Эрдэнэбилигийн Одбаяр танилцуулна. Одбаяр сайдын микрофон 5 номер.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрж мэндчилье.

Тэгээд Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан мэдээлэл ирүүлэх, явц үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа үр дүнг үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулж, Засгийн газарт танилцуулах гэж заасныг үндэслэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.3-д заасан аргачлалыг баримталсан болно.

Мөн Засгийн газрын 206 дугаар тогтоолын 8.5-д Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулан холбогдох тайланг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албан тус тус хүргүүлнэ гэж заасны дагуу 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээний цахим мэдээллийн сан unelgee.gov.mn Монгол Улсын хуулийн 89, Улсын Их Хурлын 104, Улсын Их Хурлын Байнгын хорооны 79 тогтоол, нийт 272 шийдвэрийн 1550 заалт

бүртгэлтэй бөгөөд хэрэгжилт нь дунджаар 66,4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс Төсвийн байнгын хорооны гаргасан 1 тогтоолоор үүрэг чиглэл болгосон 28 заалтын хэрэгжилт дунджаар 82,5 хувь буюу хэрэгжих шатдаа гэж дүгнэгдсэн байна. Тэгээд та бүхэн Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай танилцахыг хүсэж байна. Танилцуулгыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Чадраабалын Өнөрбаяр дарга танилцуулна.

Ц.Даваасүрэн: Танилцуулгаа өөрөө хийчихлээ шүү дээ. Би өөрийг чинь танилцуул гэсэн шүү дээ.

Э.Одбаяр: Тэгье. Эхний слайдууд саяын оршилтой холбоотой давхардчихаж байгаа учраас жоохон хойш нь явуулчихъя.

Төсвийн байнгын хороотой холбоотой 1 заалтыг гаргачихъя. Төсвийн байнгын хорооноос гарсан Монгол Улсын тогтвортой байдлын тухай, Ирээдүй өв сангийн тухай, Төсвийн тухай хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа тул цаашид төсвийн эрх зүйн орчныг тогтвортой мөрдөж ажиллах тусгай шаардлагын үйлчлэлийг хойшлуулах, өөрчлөлт оруулахыг хориглох, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах санал боловсруулж шийдвэрлүүлэхээр 3 ажил төлөвлөсөн байна.

Энэ ажлыг Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж тайлагнасан бөгөөд 2016 оноос хойш ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсан. Хөгжлийн банкныг төсвийн бүрэлдэхүүн хэсэгт оруулсан, ковидын үеийн болон дараах үеийн эдийн засгийн хямрал болон Орос, Украйны хямралт байдал зэргээс шалтгаалан төсвийн хуулиудад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд боловсруулагдсан. Эдгээр хямралт байдлаас хойш эдийн засаг тогтвортой байх үед Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг дагаж мөрдөн ажиллаж байна гээд энэ ажлыг жишээ нь 100 хувиар үнэлсэн байна.

Дараагийн заалт нь төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлж, төсвийн гадуурх зардлыг хориглох хянахад Монгол Улсын Их Хурал, Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам зэрэг холбогдох байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, санал бэлтгэх, танилцуулах, шийдвэрлүүлэх гэдэг үүрэг чиглэл өгөгдсөн. Энэ дээр төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн гадуурх зардлыг хориглох хянахад Монгол Улсын Их Хурал, Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам зэрэг холбогдох байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, санал бэлтгэх, танилцуулах шийдвэрлүүлэх тухай заалт нь тодорхойгүй байна. Ингээд хугацаа болоогүй гэдэг ангилалд бас орсон байна. Энэ 3 заалт нь тэгээд Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж энэ ажлыг хийж байгаа юм байна.

Тэгээд ерөнхийдөө бол нийтдээ 28 заалттай 1 тогтоол гарсан. Энэ 28 заалттай тогтоолын дундаж биелэлт нь 82,5 буюу хэрэгжих шатандаа, зарим заалтууд нь хэрэгжсэн, зарим заалтууд нь хугацаа болоогүй гэдэг ангилалтай байгаа.

Огт хэрэгжээгүй 1 заалт байгаа нь аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг боловсруулан баталж бүрдүүлэх жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган биелэлтийг хянах гэдэг Хэрэг эрхлэх газар, 14 яам хариуцаж хийхээр энэ заалт биелэгдээгүй байна гэж дүгнэгдсэн байна.

Тэгээд Байнгын хорооны гишүүдийн зүгээс асуух асуулт байвал хариулъя.

Ц.Даваасүрэн: Одбаяр сайдад баярлалаа. Тэгэхдээ энэ бол Их Хурал ер нь нэлээн онцгой ач холбогдол өгч, хэлэлцэх ёстой асуудал. Одоогийн энэ байдлаар тараагдсан материал энэ тэр юмыг харахад зүгээр нэг ёс төдий маягаар хандах гээд байна шүү дээ. Ерөнхий сайдын мэдээлэл тийм болсон байна. Өөрөө ч орж ирэхгүй байна. Нөгөө талаараа Их Хуралд хандаж байгаа хандлага чинь ерөөсөө нэг тийм биелэлтээ хар л даа. 66 хувьтай гээд. Үгүй ээ, Их Хурлын тогтоол, хууль хэрэгждэггүй байх юм бол энэ чинь тэгээд юу хэрэгжих юм. Ер нь бол ийм зүйлийг сонсохдоо Их Хурал ажлын хэсэг гаргаж байж өөрийнхөө гаргасан тогтоол шийдвэрийг биелж байна уу, үгүй юу гэж сайн үздэг байх хэрэгтэй. Энд 4 жил бид нарыг ямар жаргаад ир гэж явуулсан биш дээ.

Их Хурлын гаргаж байгаа шийдвэр нь хэрэгждэггүй байх юм бол энэ төр чинь тэгээд яаж явах юм. 66 хувьтай гэж байна шүү дээ. Тэгээд ингээд нэг ёс төдий хэлэлцсэн болоод өнгөрөх гэж байна шүү дээ.

Энийг ер нь ингэвэл яадаг юм. Бас яг энэ оруулж ирсэн тайлан дээр нь өөрсдөө ажлын хэсэг байгуулаад үзэх хэрэгтэй. Одоо жишээлбэл энэ дээр ийм байгаа байхгүй юу. Түр хорооны тогтоол энд бол огт дурдагдахгүй байгаа байхгүй юу. Гэтэл Оюутолгойн түр хороогоор бид нар Дубайн гэрээг цуцалсан уу, цуцалсан. Гэтэл Дубайн гэрээг цуцалчхаад байхад өнөөдөр нөгөө компани янз бүрийн хураамжуудаа авсан хэвээрээ л байгаад байна шүү дээ. Хүчингүй болгочхоод байхад. Тэгэхээр энэ Их хурлын гаргасан шийдвэрийг ялгаж үзэж болохгүй. Түр хорооных ч тэр, Байнгын хорооных ч тэр ижил. Их Хурлын тогтоол энэ 3 тогтоол гурвуулаа ижил түвшинд хэрэгжих ёстой. Гэтэл одоо орж ирэхдээ яаж байна. Их Хурлын тогтоол нь орж ирээд, Байнгын хорооны тогтоол нь яригдсан болоод, түр хорооны тогтоол нь бүр дурдагдчих ч үгүй байна шүү дээ. Тэгээд ингэж болохгүй шүү дээ. Энэ чинь Их Хурал байхгүй юу. Төр байхгүй юу. Засийн газар бол хэрэгжүүлэх, гүйцэтгэх ёстой газар байхгүй юу. Тэгэхээр энэ хандлагаа бид нар жоохон өөрчилж явахгүй бол сонссон төдий болоод өнгөрөөд байвал Их Хурлын шийдвэр гэж юм огт хэрэгжихгүй болно.

Энэ дээр асуух асуулттай гишүүдийн нэрс авъя. Горимын санал гаргаж болно шүү дээ. Батжаргал гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүний нэр орохгүй байна гээд байх юм. Ганхуяг гишүүнийх орохгүй байна. Ганхуяг гишүүн орлоо. Ингээд ирцээрээ Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Байнгын хорооны эрхэм гишүүддээ дахиад мэнд хүргэе. Өнөөдөр ч нэлээн идэвхтэй л хуралдаж байна. Төрийн хяналт шалгалтын хэрэгжилтийн тайлан сонсох гэж байна. Би байнгын хорооны даргатай санал нэг байна.

Хэрэгжилтийн тайланг нь хэлэлцэх гэж байхад танилцуулгынх нь байгаа царай энэ. Юу ч танилцуулчхав. Бичгээр ирсэн тайлан нь байхгүй. Бид нар харж амжаагүй. Төрийн байгуулалтын байнгын хороо, бусад Байнгын хороо дээр харьяалах хэсгээрээ ороод л явах л байлгүй. Бодвол тэр нь байхгүй. Тэгээд энэ төрийн хяналт шалгалтын хариуцсан сайд гээд Одбаяр гээд 1 сайд байгаа. Сайдаасаа илүү төрийн алба хашаад байгаа хүн байгаа бол тэр Өнөрбаяр гэдэг дарга улс төржсөн мэдэгдэл энд тэнд хийж явна. Би бүр тодорхой хэлье.

Дархан-Уул аймаг дээр очиж шалгалт хийсэн байна лээ. Цагдаагийн мөрдөн байцаалт шиг баахан юм хийгээд, төрийн байгууллагуудад тайлбар өгөх боломж өгөөгүй.

2 дугаарт төрийн ажил явдаг зарчмаараа яваагүй, дүгнэлт нь эцэслэгдээгүй хүмүүст тараагдаж, хариултаа аваагүй, процесс нь яваагүй байхад улс төрийн биш албан тушаал хашиж байгаа хүн улс төрийн мэдэгдэл хийж, хүмүүсийн нэр төрд халддаг. Би өөрийнхөө бас тусгуулж явсан, хийж яваа, хэрэгжүүлж байгаа ажлуудынхаа гүйцэтгэлийг та нарыг бас аятайхан шахаад явж байгаа байх гэж хараад л явж байгаа.

Тийм учраас бас Дархан-Уул аймгийнхаа өөрийнхөө сонгогдсон, 2 дахь удаагаа надад итгэл өгсөн энэ газрын танай байгууллагаас хийсэн хариуцлагагүй улс төрийн мэдэгдлийг чинь араас бас мэдээлэл тодруулга авсан. Нуль улс төржилт. Тэгээд шүүх, цагдаадаа өг л дөө та нар тэгээд. Төрийн алба, ажил явдаг зарчмаараа явдаггүй. Тэгээд оруулж ирж байгаа тайлан нь энэ.

Монгол Улсын Их Хурлын хамгийн чухал ажил бол хууль батлах, хуулийн хэрэгжилтийг шаардах, хяналт тавих ийм л үүрэгтэй байгууллага шүү дээ бид нар.

Монголын төр төрийн эрхийг барих дээд байгууллага. Төрийн эрхийг барих дээд байгууллагадаа ингэж хандаж байгаа бол энэ Үндэсний хороо, танай энэ ажлын алба ямар ажил хийгээд явж байдаг юм. Ийм байдалтай байж боломгүй байна. Тэгэхээр би ямар байр суурь илэрхийлж байгаа вэ гэхээр горимын санал гаргаж байна. Миний горимын саналаар шууд санал хураалгаж өгөхийг бас Байнгын хорооны даргаас Дэгийн тухай хуулиараа хүсье. Хэлэлцэх асуудлыг хойшлуулъя. Хойшлуулаад Төсвийн байнгын хороо дээрээсээ ажлын хэсэг байгуулъя. Төсвийн байнгын хороон дээрээс ажлын хэсэг байгуулаад, нэлээн няхуур сайн үзэж байгаад дахиж хэлэлцье гэсэн ийм санал гаргаж байна. Горимын санал хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүний гаргасан Улсын Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналтын тайланг ажлын хэсэг гаргаад, тэгээд хэлэлцье. Хойшлуулж өгөөч гэсэн ийм горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ ахиад нөгөө техникийн саатал чинь хэвээрээ байна шүү дээ.

Юу энэ юу шүү. Их Хурлын тогтоолын хэрэгжилтээр яриад байгаа юм. Тэгэхээр нөгөө 1 Байнгын хороон дээр ярих биш юм. Манай байнгын хорооноос зөндөө гарсан юм байгаа байхгүй юу. Төсвийг дагаж гарсан тогтоолын хэрэгжилтүүд энэ тэр гээд. Уг нь тэгмээр л байгаа юм л даа. Тэгэхдээ тэгэхгүй байгаад байна шүү дээ.

Тийм учраас манай Байнгын хорооны хороо хойшлуулчихъя. Хэдүүлээ тэгэх үү. Тэгэхдээ ер нь ингэж хэлэлцэх хэрэгтэй. Их Хурлынхаа гарсан шийдвэрийг бид нар хэрэгжихгүй байна. 66 хувьтай гээд ороод ирэхэд окэй гээд сууж байж болохгүй шүү дээ. Энэ төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас гар санал хураалт явуулчихъя. Гараар санал хураалт явуулъя гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Хэдээс вэ. 19-12 дэмжигдсэн байна. Ингээд гар өргөж санал хураалт явуулъя.

Түрүүний горимын саналыг хүчингүй болгох санал хураалт унасан шүү дээ. тэрийг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дамдиннямын саналыг хүчингүй болгож байна. 19-11 дэмжигдсэн байна.

Одоо ингээд Дамдинням гишүүний гаргасан хойшилъё гэсэн горимын саналаар дахин санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. Бэлтгэл хангаж байж хуралдъя. Бэлтгэл хангаж байж сонсъё. 19-10 дэмжигдсэн байна. Энэ зөв байх гишүүд ээ. Их Хурал гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хатуу хяналт тавьдаг байх ёстой. Тэгж л байж Их Хурал шүү дээ.

Их хурлын үндсэн хийх ажил хууль тогтоох, хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавих ийм л 2 ажилтай шүү дээ. Хууль гаргаж, үйлдвэрлэлчхээд, тэгээд араас нь хяналт тавьдаггүй, анхаардаг ч үгүй ёс төдий ёсчлоод, энд жишээлбэл ийм заалт орж ирсэн байгаа байхгүй юу.

519 заалтыг цаашид хасъя гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ, энэ чинь юу гэсэн үг юм. 519 заалтаар бид нар үүрэг өгсөн байна шүү дээ. Одоо хугацаа нь дуусчихлаа. Энийг хэрэгсэхгүй болгоё гэж байгаа байхгүй юу. Ийм байж болохгүй шүү дээ. Их Хурлын гаргасан тогтоол, хуультай эн зэрэгцэнэ.

Тийм учраас заалт нэг бүр нь хэрэгждэг байх ёстой. Тэгэхээр энийг хойшлуулах асуудлыг гишүүд ихэнх нь дэмжсэн нь зөв гэж үзэж байна. Ингээд 4 дэх асуудлыг хойшлуулаад, хуралдааны бэлтгэл хангасны дараа хуралдъя.

Төсвийн байнгын хорооны бие даасан хуралдаан дууслаа.

12.54 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ